

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСЭЭС 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД
ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2025.04.30

д/д	Арга хэмжээний нэр	Зохион байгуулсан арга хэмжээ
ОРХОН АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ:		
1	Аймгийн “Төгөлдөр Солонго” бүжгийн клубтэй хамтран иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, бүжгийн спортыг сурталчлах ажлын хүрээнд Шугаман бүжгийн сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах.	“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Шугаман бүжгийн холбоотой хамтран 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн "Шугаман бүжиг"-ийн үнэ төлбөргүй сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв, Бямба, Ням гарагуудад 08:00 цагаас "Төгөлдөр-Солонго" бүжгийн клубт зохион байгуулж байна. Тус арга хэмжээнд өнөөдрийн байдлаар 600 иргэн хамрагдсан.
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Нөхөрсөг Бочи” тэмцээнийг зохион явуулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Нөхөрсөг Бочи” тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 17-ний өдөр БТСГ-ын А зааланд зохион байгууллаа. Тус тэмцээнд Гэрэл залуучуудын төв, 7-р сургууль, 18-р сургууль, 15-р сургууль, 20-р сургууль, 8-р сургуулиудын нийт 65 гаруй тусгай хэрэгцээт хүүхэд, иргэд, багш нар хамрагдлаа. Тэмцээний нээлтийн арга хэмжээний үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай бочигийн төрлөөр хичээллэхэд зориулж хэрэглэл, материал авч өгсөн “Ачит Ихт” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлэе.
3	Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөнгөн атлетикийн ААШТ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Хангарьд спорт цогцолборын Хөл бөмбөгийн талбайд зохион байгуулагдсан. Гэрэл залуучуудын төв, 7-р сургууль, 8-р сургуулиудаас нийт 50 гаруй тамирчин оролцсон.
4	"Гүйж суръя" биеийн тамирын арга хэмжээ	Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд хамруулах зорилгоор “Гүйж суръя” арга хэмжээг 7 хоног бүрийн Бямба гарагийн 07:20-08:30 цагуудад Биеийн тамир, спортын газрын Б зааланд зохион байгуулж нийт 8 байгууллагын 320 хүн хамрагдсан.
5	Софт волейболын холимог багуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээн	Орхон аймгийн Софт волейболын 2025 оны аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Жаргалант сумын ЗДТГ-ын спорт зааланд холимог багаар 3 насны ангиллаар зохион байгуулагдаж нийт 22 багийн 110 тамирчин оролцсон.

6	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны хүрээнд	Иргэдэд эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал болгох, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Биеийн тамирыг дэмжигч байгууллагуудын дунд (фитнес клубүүд, алхалтын холбоо, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Шугаманбүжгийн холбоо) 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр буудлага, корнхол, олс таталтын төрлөөр тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд 10 байгууллагын 90 гаруй тамирчин амжилттай оролцсон.
7		Аяны хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд олс таталт, хөгжөөнт буухиа, дартсын тэмцээн, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд гардээр суниалтын тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй ангиллаар амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 113 тамирчин оролцлоо.
8	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг “Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах” арга хэмжээний хүрээнд 2025 оны хаврын сорилын үйл ажиллагааг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүүхдүүд, албан хаагчдаас авч эхлэн сорилын программд шивэлт хийж байна.

-----oOo-----